

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVIII (610)

DOI: 10.22353/ms20244802

МОНГОЛ БРАХМИ БИЧИГ СУДЛАЛ

Ч.Адангаа
Б.Даваасүрэн

Аннотация: Монголы в течении своей истории создали и использовали для делопроизводства более 10 различных систем письма, отличавшиеся по происхождению и возникавшие в разное историческое время. Учёные раньше констатировали об использовании монголами в прамонгольский период развития монгольского языка рунический вид письма. Однако, начиная с 2020-ых годов учёные выдвигают гипотезу, что монгольское брахми письменность была одним из видов прамонгольского периода. Письменный памятник обнаруженный в 1970 году на территории Булганского аймака Монголии, именуемый как «Хүйс толгойн бичээс» (Надпись из горы Хүйс) попала в поле зрения учёных и с 2010 года по инициативе турецких учёных была создана совместная исследовательская группа, которая работала над дешифровкой данного письма. В состав которого входила шесть учёных из таких стран как Германии, Франции и Турции. После чего учёные пришли к интересному выводу, что система гласных и согласных фонем идентична с системой прамонгольского языка, что внесла весомый вклад в области исследования истории монгольских письменностей.

Ключевые слова: монгольское брахми письменность, графемика, письменности монголов, письменные памятники, тибетское письмо, письмо Пагбы.

Монгол брахми бичиг буюу Хүйс толгойн бичээс.

1.Брахми үсэг нь Энэтхэгийн хамгийн эртний бичгийн системүүдийн нэг бөгөөд өнөөгийн Энэтхэгийн бичиг үсгийн үндэс, эх сурвалж болжээ. Энэ үсгийн систем нь МЭӨ III зууны үед үүссэн гэж үздэг бөгөөд МЭӨ III зууны Морины эзэнт гүрний хаан Ашокийн үед хамаарах олон бичээс Брахми үсгээр байдаг.

Брахми үсгийн гарал үүслийг тодорхойлох олон таамаглал байдаг бөгөөд үүнийг Финик үсэгтэй холбоотой гэж үздэг. Мөн Энэтхэгийн дотоодод үүссэн бичиг үсэг гэж зарим судлаач холбодог. Финик үсгийн нөлөөнд үндэслэсэн гэж үзвэл Брахми үсэг нь өөрийн соёлын онцлогийг тусгаж, Энэтхэгийн олон янзын хэлний онцлогт тохирсон шинэ бүтцийг бий болгосон байна.

Брахми үсэг нь үндсэндээ абугида системтэй учир үсэг бүр үндсэн нэг эгшигтэй бөгөөд нэмэлт тэмдэг хэрэглэн эгшиг үсгийг өөрчилдөг. Хэвтээ тэнхлэгт зүүнээс баруун гар тал руу бичдэг байсан бөгөөд олон хэл аялгууны дунд тэгш үйлчилж чаддаг бүтэцтэй байжээ. Энэ бичгийн систем нь Энэтхэгийн хэлнүүдийн тусгай авиа зүй, дуудлагын онцлогийг тусгасан тул

аажмаар Энэтхэгийн янз бүрийн бичгийн системийн эх үндэс болж хувирчээ.

Брахми үсгийн системээс аажмаар Энэтхэгийн олон бичиг үсэг үүсэж хөгжсөн байдаг. Жишээлбэл:

- Деванагари үсэг (Санскрит, Хинди, Маратхи гэх мэт хэлэнд хэрэглэгддэг)
- Тамил үсэг
- Каннада үсэг
- Төвөд үсэг
- Бирма үсэг
- Монгол брахми үсэг гэх мэт.

Энэтхэгийн хойг болон Зүүн Өмнөд Азийн олон улс оронд Брахми үсгийн нөлөө маш их тархсан. Эдгээр улс орон өөрсдийн хэлний онцлогт тохируулан Брахми үсгээс шинэ үсгийн системүүдийг бүтээж хэрэглэж эхэлсэн байна.

Судлаачид Брахми үсгийг орчин үеийн Энэтхэгийн болон Зүүн Өмнөд Азийн олон бичгийн эх сурвалж гэж үздэг бөгөөд энэхүү үсгийн систем нь соёл хоорондын харилцаа, худалдаа, шашны түгээн дэлгэрэлтийн улмаас өргөн тархсан гэж дүгнэдэг.

2. Монгол брахми бичгийн тухай. Монгол брахми бичгийн үсэг тэмдгийн үүсэл нь нэн эртний санскрит үсэг бичиг болох абугида (abugida) Брахми бичгээс эхтэй бөгөөд Гупта (Gupta) брахми бичгээс уламжлалтай юм. Энэ нь нийтийн тооллын 400 оны орчим бие даасан бичиг болон хөгжиж, Энэтхэгээс умард зүгт Хималай нуруу, Таримын хотгороор дамжин Төвөд, Монгол, Хятад, Японд тархсан байна (*Genealogie der von der protosinaitischen Schrift abgeleiteten Alphabete*, n.d.).

V-VI зууны үед Таримын хотгорын орчимд Котон (Khotan), Тохариан (Tocharian), Тумчуг (Tumshuqese), Согд (Sogdian), Уйгур (Uyghur), Монгол (Mongolian) брахми бичгүүд зэрэгцэн хэрэглэгдэж байсан (Солонгод & Хурцбаатар, 2021, х. 34-42). Эдгээр бичгийн системийн нэрд тухайн үндэстний хэл заагдсан бол “Брахми бичиг” гэх нь тухайн хэлний авиа, дуудлагад тохируулан шинэ үсэг тэмдэг нэмсэн болохыг илэрхийлж байна (Maue, n.d.).

Өөрөөр хэлбэл, өмнөх нь хэлийг, дараах нь үсэг тэмдгийг зааж байгаа юм. Нийтийн тооллын 650 онд Төвөд үсэг, 1269 онд Пагва дөрвөлжин бичиг бүтээгдсэн нь бүгд Брахми бичгийн нөлөөгөөр зохиогдсон байдаг (*Die Mongolische Brahmi-Schrift*, n.d.).

Хүйс толгойн бичээс буюу Монгол брахми бичгийг илрүүлсэн нь.

Хүйс толгойн бичээсийг 1974 онд М.Шинэхүү, Д.Цэнд нар анх илрүүлж, М.Шинэхүү тус хөшөөний бичээсийг сийрүүлэн буулгаж, бичээсний талаар «Түүхийн судлал» сэтгүүлд тусгай өгүүлэл бичиж хэвлүүлжээ.

Тэрээр тус өгүүлэлдээ:

“Газраас олонтоо олдсон янз бүрийн үсэг бичгийн дурсгалуудтай ер тохирохгүй байдал зэргээс үзвэл энэ бичээсийг Брахми бичиг хэмээн

тааварлах үндэстэй мэт санагдах авч, улмаар эрдэмтдийн нягтлан үзэж шүүн тунгаахад зориулан уг олдворын байдал төрх (дүрс), үсэг зурлагын маягийг тодруулахаар хойно толилууллаа” (Солонгод & Хурцбаатар, 2021, х. 306-317).

Гадаад, дотоодын эрдэмтдийн судалгаанд энэ бичээсийг танилцуулснаар Монгол брахми үсгийг тайлж унших, хөшөөний бичээсийг судлах анхны суурийг тавьсан юм.

Энэтхэгийн хойг болон Зүүн Өмнөд Азийн олон улс оронд Брахми үсгийн нөлөө маш их тархсан. Эдгээр улс орон өөрсдийн хэлний онцлогт тохируулан Брахми үсгээс шинэ үсгийн системүүдийг бүтээж хэрэглэж эхэлсэн байна. Судлаачид Брахми үсгийг орчин үеийн Энэтхэгийн болон Зүүн Өмнөд Азийн олон бичгийн эх сурвалж гэж үздэг бөгөөд энэхүү үсгийн систем нь соёл хоорондын харилцаа, худалдаа, шашны түгээн дэлгэрэлтийн улмаас өргөн тархсан гэж дүгнэдэг.

Монгол брахми бичгийн тухай.

Монгол брахми бичгийн үсэг тэмдгийн үүсэл нь нэн эртний санскрит үсэг бичиг болох абугида (abugida) Брахми бичгээс эхтэй бөгөөд Гупта (Gupta) брахми бичгээс уламжлалтай юм. Энэ нь нийтийн тооллын 400 оны орчим бие даасан бичиг болон хөгжиж, Энэтхэгээс умард зүгт Хималай нуруу, Таримын хотгороор дамжин Төвөд, Монгол, Хятад, Японд тархсан байна (Genealogie der von der protosinaitischen Schrift abgeleiteten Alphabete, n.d.).

V-VI зууны үед Таримын хотгорын орчимд Котон (Khotan), Тохариан (Tocharian), Тумчуг (Tumshuqese), Согд (Sogdian), Уйгур (Uyghur), Монгол (Mongolian) брахми бичгүүд зэрэгцэн хэрэглэгдэж байсан (Хурцбаатар, 2021, х. 34-42). Эдгээр бичгийн системийн нэрд тухайн үндэстний хэл заагдсан бол “Брахми бичиг” гэх нь тухайн хэлний авиа, дуудлагад тохируулан шинэ үсэг тэмдэг нэмсэн болохыг илэрхийлж байна (Maue, n.d.).

Өөрөөр хэлбэл, өмнөх нь хэлийг, дараах нь үсэг тэмдгийг зааж байгаа юм. Нийтийн тооллын 650 онд Төвөд үсэг, 1269 онд Пагва дөрвөлжин бичиг бүтээгдсэн нь бүгд Брахми бичгийн нөлөөгөөр зохиогдсон байдаг (Die Mongolische Brahmi-Schrift, n.d.).

Хүйс толгойн бичээс буюу Монгол брахми бичгийг илрүүлсэн нь.

Хүйс толгойн бичээсийг 1974 онд М. Шинэхүү, Д. Цэнд нар анх илрүүлсэн бөгөөд М. Шинэхүү уг бичээсийг сийрүүлэн буулгаж, “Түүхийн судлал” сэтгүүлд анхны өгүүллээ нийтлүүлжээ. Уг судалгаанд бичээсийг Брахми бичигтэй холбоотой хэмээн таамагласан байдаг. Судлаачид дараа нь бичээсийн агуулга, дүрсийг нягталж судлах ажлыг үргэлжлүүлсэн (Солонгод & Хурцбаатар, 2021).

1976 онд Монгол Улсын эрдэмтэн Д. Навааны санаачилгаар Хүйс толгойн бичээс-ийг Улаанбаатар хотод авчран, түүхийн ховор үнэт дурсгал хэмээн хүндэтгэн хамгаалуулсан (Наваан, 1976).

1978 онд уг бичээс нь гадаадын эрдэмтдийн анхааралд өртөж, Туркийн эрдэмтэн, сэтгүүлч Nejat Dizabekirli тус хөшөөний фото зургийг мэргэжлийн аппарат хэрэгслээр буулган нийтэлжээ. Тэрээр “Энэ бол Хангайн уулнаас олдсон бичээс юм. Түүний үсгийг уншиж чадаагүй байсаар. Сонсоход Хүннүгээс гаралтай юм гэнэ” (Dizabekirli, 1979, р. XX) хэмээн тэмдэглэсэн байдаг.

2005 онд эрдэмтэн Б. Напил Хүйс толгойн хоёр гэрэлт хөшөөний бичээсний фото зургийг авч, цаасан дээр буулган дармал үйлджээ. Тэрээр мөн өөрийн авсан олон зургаа Дитер Мауэ, Л. Хурцбаатар зэрэг эрдэмтдэд харамгүй өгч, уншуулснаар тус хөшөөний бичээсний нууцыг тайлах үйл явц урагшилсан юм. Тиймээс Дитер Мауэ болон Л. Хурцбаатарын анхны сэргээн тайлалт нь Б. Напилын фото зургуудыг үндэслэн хийгдсэн (Хурцбаатар, 2019, х. 75).

Хүйс толгойн бичээс нь Монголын эртний түүх, соёлын чухал дурсгал. Энэ дурсгал нь Түрэгийн үеийн бичээс бүхий хөшөө бөгөөд түүх, соёлын олон мэдээллийг агуулсан байдаг. Хүйс толгойн хөшөө нь ойролцоогоор VIII зууны үед хамаарах бөгөөд Түрэгийн хаант улсын үед босгосон гэж үздэг.

Энэхүү хөшөөний бичээс нь Түрэгийн хаант улсын түүхийг өгүүлж, тухайн үеийн төр, цэрэг, язгууртнуудын тухай мэдээллийг хадгалсан байдаг. Бичээс нь эртний Түрэгийн бичиг үсгээр бичигдсэн бөгөөд түүхч, археологичдын хувьд маш үнэ цэнтэй судлагдахуун болсон. Бичээсний агуулгаас үзэхэд тухайн үедээ улс төр, цэргийн үйл ажиллагаа, түрэгийн хаадын амжилт, баатарлаг явдлууд, мөн тухайн нутагт амьдарч байсан ард түмний соёл, шашин шүтлэгийг тусгажээ.

Тухайн цаг үеийн түүхэн үйл явдлыг энэхүү хөшөөнд тэмдэглэсэн учир түүх судлаачдын дунд “Түрэгийн Руни бичээс” хэмээн нэрлэгдэх нь ч бий. Хүйс толгойн хөшөө нь Монголын болон Төв Азийн бусад эртний түүхэн бичээснүүдтэй хамт судлагдаж, Монголын эртний түүх, Түрэгийн соёлын талаар илүү гүнзгий ойлголт өгдөг.

Хүйс толгойн хөшөө нь Монгол Улсын түүх, соёлын өвийн нэг хэсэг, судалгаа шинжилгээний эх хэрэглэгдэхүүн болохын хувьд хамгаалбал зохих түүх, соёл, бичиг үсгийн ховор нандин дурсгалын тоонд багтсан байдаг.

Монгол брахми бичгийн үеийн тогтолцооны онцлог.

Монгол Брахми бичиг нь Монголын нутаг дэвсгэрт хэрэглэгдэж байсан олон зүйл бичиг үсгийн нэг бөгөөд Энэтхэгийн хойгоос гаралтай бичиг үсэг боловч монгол хэлний залгамал шинжэд нийцүүлэн өөрчилсөн гэж үздэг.

Монгол Брахми бичиг үсэг дараах онцлогтой:

1. Эгшиг, гийгүүлэгчийн зохицол: Монгол хэлний эгшиг, гийгүүлэгч зохицох ёсыг нэлээд тогтолцоотой тэмдэглэдэг. Тиймээс Монгол Брахми бичигт эгшиг зохицох ёс чанд мөрдөгддөг байсан гэж эрдэмтэн судлаачид үздэг.

2. Эгшиг авиа тэмдэглэх зарчим: Монгол Брахми бичигт гийгүүлэгч бүр үндсэн *a* эгшгээр амилсан байдаг бөгөөд *a*-аас бусад эгшиг авиаг тэмдэглэхдээ тусгай нэмэлт тэмдэг хэрэглэдэг. Өвөг монгол хэлний *i*, *o*, *ö* эгшиг авиаг илтгэдэг туслах тэмдгийг гийгүүлэгч үсгийн дээд талд харин *u*, *y* авиаг илтгэдэг туслах тэмдгийг гийгүүлэгч үсгийн доод талд бичдэг.

3. Гийгүүлэгч авиа тэмдэглэх зарчим: Монгол Брахми бичигт монгол хэлний үндсэн гийгүүлэгч авиаг тэмдэглэх тодорхой тогтолцоотой байжээ. Тухайлбал, зөөлөн, хатуу гийгүүлэгчийг ялган тэмдэглэх системтэй байсан нь тухайн хэлний авиа зүйн онцлогийг тусгасны баталгаа юм.

4. Нэр үг ба үйл үгийн залгавар бүтээвэр: Монгол брахми бичигт нэр үг, үйл үгийн араас ордог залгавар бүтээвэр хөгжсөн системтэй бичиг байжээ.

5. Дуудлага зохицуулах онцлог: Монгол хэлний авиа зүйн онцлогийн тухайд гэвэл брахми бичгийг тухайн үеийн монгол хэлний дуудлагад тохируулж боловсруулсан байна.

Өвөг монгол хэлтэй холбогддог энэхүү түүхэн дурсгал нь монголчуудын түүх, соёл, хэл шинжлэлийн үнэ цэнтэй эх сурвалж мөн бөгөөд монголын эртний бичгийн соёл, хэлний хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулсан билээ.

Монгол брахми бичгийн эгшиг үсгийн тогтолцоо.

Хүйс толгойн бичээст хоёр бие даасан эгшиг, туслах тэмдгээр илэрдэг дөрвөн эгшиг үсэг тэмдэглэгдсэн байдаг. Босоо тэнхлэгт буюу дээрээс доош чиглэлд бичдэг, мөр шилжихдээ зүүнээс баруун гар тийш бичдэг.

Хүйс толгойн бичээсний монгол брахми бичгийн эгшиг үсгийг хэрхэн тэмдэглэснийг үзүүлбэл:

1. Үгийн эхэнд ордог чанга, эр эгшиг $\mathcal{A}$ *a*; үгийн эхэнд ордог чанга, эр эгшиг $\mathcal{B}$ *u* гэсэн хоёр авиа бие даасан үсгээр тэмдэглэгддэг.

2. Хэлний арын $\mathcal{I}$ *i*, $\mathcal{O}$ *o*, $\mathcal{U}$ *u* гэсэн гурван эгшиг үсэг болон хөндий $\mathcal{I}$ *i*, $\mathcal{O}$ *ö*, $\mathcal{U}$ *ü* гурван эгшиг үсэг туслах тэмдгээр илэрдэг.

Доор хүснэгтэд нийт 29 гийгүүлэгч үе-үсгийг эгшиг үсгээр амилуулан бичсэн байгаа нь:

Брахми үсгийн гарал, бүтэц, Ази даяар тархсан хэлбэрүүдийг тоймлон үзсэнээс гадна, Монгол Брахми бичгийн авиазүйн зохицол, үсэг тэмдгийн тогтолцоо, бичлэгийн зарчим, үе бүтцийн шинжийг тодорхойлж, төвөд, тохариан, дөрвөлжин бичгийн хэлбэртэй харьцуулсан нь энэхүү бичиг нь Монгол хэлэнд онцгойлон тохируулан өөрчлөгдсөн дотоод бичиг байсныг баталж байна.

Хүйс толгойн бичээсийг судалснаар Монгол бичгийн түүхийг улам гүнзгийрүүлж, бичиг үсгийн үүсэл гарлын талаарх өнөөгийн ойлголтыг шинэ түвшинд хүргэх боломжтой болохыг энэ судалгаа харуулж байна. Монгол Брахми бичиг нь монголчуудын бичиг үсгийн түүхийг XIII зуунаас хэдэн зуунаар урагшлуулах нотолгоо болох төдийгүй монгол хэлний дотоод хөгжил, бичгийн соёлын хөгжилд үнэтэй хувь нэмэр оруулах эх сурвалж гэдгийг дахин баталлаа.

Цаашид Монгол Брахми бичгийн дотоод хэлбэр, дүрмийн тогтолцоог гүнзгийрүүлэн судалж, түүний үндсэн дээр сэргээн унших аргыг боловсронгуй болгох нь чухал бөгөөд энэ нь монголчуудын эртний бичгийн өвийг бүрэн утгаар нь сэргээж, танин мэдэхэд үнэтэй хувь нэмэр оруулах юм.

Ном зүй

Монгол хэлээр:

Баттулга, Ц. (1994). *Бугатын гэрэлт хөшөөний бичээс*. 林梅村 布古特所出粟特文突厥可汗纪功碑考. 《民族研究》, Бээжин.

Доржсүрэн, Ц. (1958). *1956-1957 онд Архангай аймагт археологийн шинжилгээ хийсэн тухай*. Улаанбаатар.

Наваан, Д. (1976). *1976 оны хээрийн шинжилгээний тайлан ТХГБС*. Улаанбаатар.

Хурибаатар, Л. (2021). *Өвөг монгол хэл – Монгол брахми бичиг*. Cologne, Germany.

Сэр-Оджав, Н. (1987). *1961 оны хээрийн шинжилгээний хэрэглэгдэхүүн*. Улаанбаатар.

Хурибаатар, Л. (2019). *1400 жилийн өмнөх өвөг монгол хэл – Хүй толгойн бичээсний судлал (HTI)*. Cologne, Germany: Elias Verlag IMoFiF e.V.

Хурибаатар, Л. (2021). *Өвөг монгол хэл – Монгол брахми бичиг*. Cologne, Germany: Elias Verlag IMoFiF e.V.

Хурибаатар, Л. (2021). *Монгол брахми бичгийг түргэн сурахуй бичиг*. Cologne, Germany: Elias Verlag IMoFiF e.V.

Гадаад хэлээр:

Maue, D. (n.d.). *Non-Indian Brāhmī Scripts along the Silk Roads*.

Dizabekirli, N. (1979). *Orhun'dan Geliyorum. Türk kül türü*, Sayı 198-199, Yıl XVII, Nisan-Mayıs.

Maue, D. (2018). *Signs and Sounds*. *Journal Asiatique*, 306(2).

Напил Базылхан. (2014). *Көне түріктердін этномэдени-тарихи деректері*. Алматы.

Rintchen, B. (1959-1961). *Corpus Scriptorum Mongolorum. Tomus 1. Fasciculus 1-12*. Ulan-Bator.

Лившиц, В. А., & Кляшторный, С. Г. (1971). *Согдийская надпись из Бугута. Страны и народы Востока, Вып. 10*. Москва.

Maue, D. (2019). *Eine Skizze der ältesten mongolischen Sprache: Die Inschriften von Brāhmī Bugut und Khüis Tolgoi*. *Journal Asiatique*, 307, 109-119. <https://doi.org/10.2143/JA.307.1.3286343>

de la Vaissière, É. (2017, August 31). *The Historical Context to the Hüis Tolgoi Inscription. The First Extant Altaic Text: An Interpretation of the Mongolic-language Hüis Tolgoi Inscription*. Presented at the 60th PIAC, Székesfehérvár, Hungary.

Цахим эх сурвалж:

SERGEJ G.KLJAŠTORNYJ and VLADIMIRA.LIVŠIC: THE SOGDIAN INSCRIPTION OF BUGUT REVISED. (Acta Orientalia Academiae Scientiarum Hungaricae, Vol. 26, No. 1, 1972) <https://www.jstor.org/stable/23657228>

«Хүйе толгой- I, II» битіктастарындағы брахми жазулы мәтіндер. <http://atalarmirasi.org/17-khuyis-tolgoy-i-ii-bitiktastaryndaghy-brakhmi-zhazuly-matinder>

Die Mongolische Brahmi-Schrift. https://de.wikipedia.org/wiki/Mongolische_Brahmi-Schrift

Mongolian Brahmi literature teaching at the National University of Mongolia: <https://www.youtube.com/watch?v=qBqHOPQKYb8>

Genealogie der von der protosinaitischen Schrift abgeleiteten Alphabete. https://de.wikipedia.org/wiki/Genealogie_der_von_der_protosinaitischen_Schrift_abgeleiteten_Alphabete

Alexandar Vovin: https://www.academia.edu/38720522/An_Interpretation_of_the_Kh%C3%BCis_Tolgoi_inscription